

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: БНА-2022/86/НА-СТА-ТШЗ

| | |
|-----------------------|--|
| Баянхонгор 2022 он | Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Б.Мөнхбат Утас: 99007576 Цахим хаяг: munkhbatb@audit.gov.mn Аудитын менежер: А.Цээням Утас: 99442140 Цахим хаяг: tseenyama@audit.gov.mn Аудитор: Н.Бунчинсүрэн Утас: 99049866 Цахим хаяг: bunchinsurenn@audit.gov.mn Цахим хуудас: www.audit.mn |
|-----------------------|--|

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

| | |
|---|----|
| 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл | 4 |
| 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан | 4 |
| 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан | 4 |
| 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан | 6 |
| 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан | 7 |
| 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан | 8 |
| 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан..... | 9 |
| 3. Аудитын тайлан | 10 |
| 3.1 Ерөнхий зүйл | 10 |
| 3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт..... | 10 |
| 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал..... | 11 |
| 3.4 Материаллаг байдал | 11 |
| 3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга..... | 11 |
| 3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв..... | 12 |
| 3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг..... | 13 |
| 3.8 Аудитын гол асуудал..... | 14 |
| 3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... | 14 |
| 3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт | 14 |
| 3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт | 15 |
| 3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал | 15 |
| 4. Аудитын илрүүлэлт | 15 |
| 4.1 Төлбөрийн акт | 15 |
| 4.2 Зөвлөмж..... | 16 |
| 5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл | 17 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |



**БАЯНХОНГОР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Номгон 1 дүгээр баг, Баянхонгор сум,
Баянхонгор аймаг, 64101
Утас, факс 7044 2584
E-mail; bayankhongor@audit.gov.mn

ЖИНСТ СУМЫН ЕРӨНХИЙ
БОЛОВСРОЛЫН СУРГУУЛИЙН
ЗАХИРАЛ М.БИБИШ ТАНАА

№ 2/114

танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.


D:\alban bichig\A4-toot.docx

005020520

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР

A large, stylized handwritten signature in black ink, written over a faint red rectangular stamp. The signature is fluid and cursive, starting with a large loop and ending with a long horizontal stroke.

Б.МӨНХБАТ

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

| Дансны код | Балансын үзүүлэлт | төгрөгөөр | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| | | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 71,267,348.09 | 67,631,472.92 |
| 33 | АВЛАГА | 12,568,698.09 | 2,453,332.92 |
| 33100 | Ажиллагчидтай холбогдсон авлага | 2,618,698.09 | 2,240,031.92 |
| 336 | Бусад авлага | 9,950,000.00 | 213,301.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 9,950,000.00 | 213,301.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 58,698,650.00 | 65,178,140.00 |
| 351 | Түүхий эд материал | 49,556,750.00 | 51,912,100.00 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 46,199,300.00 | 49,064,600.00 |
| 35130 | Эм боох материал | 3,357,450.00 | 2,847,500.00 |
| 354 | Хангамжийн материал | 9,141,900.00 | 13,266,040.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 3,101,900.00 | 3,562,050.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 5,996,600.00 | 6,385,600.00 |
| 35460 | Хүнсний материал | 43,400.00 | 3,318,390.00 |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,751,926,896.37 | 4,925,844,577.13 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 1,751,926,896.37 | 4,925,844,577.13 |
| 392 | Биет хөрөнгө | 1,718,906,937.90 | 4,892,866,993.63 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 1,623,309,815.50 | 4,782,035,612.57 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -62,259,661.00 | -51,761,529.40 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 119,458,552.95 | 138,964,468.95 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -66,636,779.29 | -70,014,395.22 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хопшил | 150,017,110.48 | 160,278,985.48 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -45,940,100.74 | -68,112,878.75 |
| 39217 | Ном | 958,000.00 | 1,476,730.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 33,019,958.47 | 32,977,583.50 |
| 39301 | Програм хангамж | 765,000.00 | 765,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -393,041.53 | -435,416.50 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 32,648,000.00 | 32,648,000.00 |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 1,823,194,244.46 | 4,993,476,050.05 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | 2,762,262.29 | 00.00 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | 2,762,262.29 | 00.00 |
| 413 | Өглөг | 2,762,262.29 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 2,762,262.29 | 00.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 1,820,431,982.17 | 4,993,476,050.05 |
| 61 | Засгийн газрын хувь оролцоо | 1,820,431,982.17 | 4,993,476,050.05 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 421,793,425.59 | 421,793,425.59 |
| 51101 | Өмч: - төрийн | 421,793,425.59 | 421,793,425.59 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 1,350,442,820.14 | 4,570,118,801.16 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 1,350,442,820.14 | 1,397,074,733.28 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 3,173,044,067.88 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 48,195,736.44 | 1,563,823.30 |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | 1,823,194,244.46 | 4,993,476,050.05 |

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Төгрөгөөр | |
|------------|--|-------------------------|-------------------------|
| | | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 2,179,020,309.04 | 4,048,471,319.50 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 1,509,411,509.04 | 3,350,635,859.00 |

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 1,509,411,509.04 | 3,350,635,859.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 1,509,411,509.04 | 00.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 1,509,411,509.04 | 00.00 |
| 1200018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого үндсэн хөрөнгө | 00.00 | 3,350,635,859.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 669,608,800.00 | 697,835,460.50 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 544,329,600.00 | 518,441,100.00 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 544,329,600.00 | 518,441,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,362,800.00 | 42,610,294.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,362,800.00 | 42,610,294.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 116,916,400.00 | 136,784,066.50 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 116,916,400.00 | 136,784,066.50 |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 691,525,899.02 | 743,599,562.93 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 691,525,899.02 | 743,599,562.93 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 648,133,633.56 | 684,201,969.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 390,752,221.26 | 380,369,212.15 |
| 210101 | Үндсэн цалин | 390,752,221.26 | 380,369,212.15 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 48,372,941.57 | 48,499,621.80 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,372,941.57 | 48,499,621.80 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 104,594,737.00 | 135,718,966.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,557,266.00 | 4,025,576.00 |
| 210302 | Түлш, халаалт | 99,527,471.00 | 131,249,390.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,000.00 | 444,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 16,729,270.00 | 12,352,594.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,843,770.00 | 2,252,524.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 9,446,600.00 | 2,258,340.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,595,000.00 | 1,575,620.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 730,000.00 | 1,127,660.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,113,900.00 | 5,138,450.00 |
| 2105 | Нормативт зардал | 24,269,450.00 | 26,103,285.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,854,750.00 | 8,139,000.00 |
| 210502 | Хоол, хүнс | 21,414,700.00 | 17,964,285.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 2,440,000.00 | 3,186,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 2,440,000.00 | 3,186,200.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,522,000.00 | 301,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,522,000.00 | 301,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 3,868,600.00 | 2,443,500.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 3,418,600.00 | 1,899,500.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 44,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 55,584,413.73 | 75,227,589.55 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 4,821,000.00 | 50,000.00 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 50,763,413.73 | 75,177,589.55 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,392,265.46 | 59,397,593.93 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,378,300.00 | 42,211,766.00 |
| 213202 | Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж | 00.00 | 13,337,436.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,674,700.00 | 3,715,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,838,830.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8,362,800.00 | 00.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,340,800.00 | 320,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 34,984.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 34,984.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 561,663.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 561,663.00 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 21,452,302.46 | 17,150,843.93 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,452,302.46 | 17,150,843.93 |

**Жинст сумын Ерөнхий Боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|------------|---|-------------------------|-------------------------|
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | 1,487,494,410.02 | 3,304,871,756.57 |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 00.00 | 131,827,688.69 |
| 225005 | Үнэ төлбөргүй гарсан зардал | 00.00 | 131,827,688.69 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | 00.00 | -131,827,688.69 |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | 1,487,494,410.02 | 3,173,044,067.88 |

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-----------------------|-----------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 669,608,800.00 | 697,835,460.50 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 669,608,800.00 | 697,835,460.50 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 544,329,600.00 | 518,441,100.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,362,800.00 | 42,610,294.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8,362,800.00 | 42,610,294.00 |
| 1320 | Орон нутгийн төсвөөс санхүүжих | 116,916,400.00 | 136,784,066.50 |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 116,916,400.00 | 136,784,066.50 |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 652,290,700.00 | 677,498,360.50 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 652,290,700.00 | 677,498,360.50 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 608,898,434.54 | 611,921,766.57 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 390,048,500.00 | 382,600,420.85 |
| 210101 | Үндсэн цалин | 316,862,718.33 | 316,764,801.80 |
| 210102 | Нэмэгдэл | 47,820,431.67 | 36,400,011.68 |
| 210104 | Урамшуулал | 25,365,350.00 | 29,435,607.37 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 47,372,677.54 | 48,847,310.22 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 34,333,279.28 | 36,295,597.13 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,307,776.92 | 3,218,306.50 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,410,053.11 | 2,575,100.73 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 784,633.99 | 614,686.65 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,536,934.24 | 6,143,619.21 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 104,594,737.00 | 135,784,066.50 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,557,266.00 | 4,025,576.00 |
| 210302 | Түлш, халаалт | 99,527,471.00 | 131,249,390.50 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,000.00 | 509,100.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 6,136,970.00 | 8,098,570.00 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,152,940.00 | 1,183,600.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 00.00 | 2,000,000.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,319,430.00 | 1,275,620.00 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,590,000.00 | 417,150.00 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 730,000.00 | 1,240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,344,600.00 | 1,982,200.00 |
| 2105 | Нормативт зардал | 31,477,450.00 | 21,859,575.00 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 1,212,200.00 | 3,279,050.00 |
| 210502 | Хоол, хүнс | 29,086,350.00 | 15,060,275.00 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,178,900.00 | 3,520,250.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 6,306,000.00 | 4,183,400.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 4,769,200.00 | 1,044,300.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,536,800.00 | 3,139,100.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 1,522,000.00 | 301,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 1,522,000.00 | 301,000.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,286,100.00 | 3,640,144.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 836,100.00 | 2,900,144.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 450,000.00 | 500,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 00.00 | 240,000.00 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 20,154,000.00 | 6,607,280.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,062,700.00 | 6,000,000.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 13,091,300.00 | 607,280.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 43,392,265.46 | 65,576,593.93 |

**Жинст сумын Ерөнхий Боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 21,378,300.00 | 48,390,766.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,674,700.00 | 9,894,500.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 00.00 | 24,838,830.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 00.00 | 13,337,436.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,703,600.00 | 320,000.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 00.00 | 34,984.00 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 00.00 | 34,984.00 |
| 2134 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт | 561,663.00 | 00.00 |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 561,663.00 | 00.00 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | 21,452,302.46 | 17,150,843.93 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 21,452,302.46 | 17,150,843.93 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | 17,18,100.00 | 20,337,100.00 |
| 5 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5) | 17,318,100.00 | 20,337,100.00 |
| 22 | ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ | 17,318,100.00 | 20,337,100.00 |
| 2200 | Дотоод эх үүсвэрээр | 17,318,100.00 | 20,337,100.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 17,318,100.00 | 20,337,100.00 |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | -17,318,100.00 | -20,337,100.00 |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | 00.00 | 00.00 |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | 00.00 | 00.00 |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | 00.00 | 00.00 |

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-------------------|--|
| C01 | 2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 419,793,425.59 | 181,872,696.74 | -270,728,550.18 | 330,937,572.15 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 133,676,960.30 | 133,676,960.30 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 419,793,425.59 | 181,872,696.74 | -137,051,589.88 | 464,614,532.45 |
| C04 | Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт | 2,000,000.00 | -133,676,960.30 | 00.00 | -131,676,960.30 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 1,487,494,410.02 | 1,487,494,410.02 |
| C08 | 2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 48,195,736.44 | 1,350,442,820.14 | 1,820,431,982.17 |
| D01 | 2021 оны 01-р сарын 30-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 48,195,736.44 | 1,350,442,820.14 | 1,820,431,982.17 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 46,631,913.14 | 46,631,913.14 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 421,793,425.59 | 48,195,736.44 | 1,397,074,733.28 | 1,867,063,895.31 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | -46,631,913.14 | 00.00 | -46,631,913.14 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 3,173,044,067.88 | 3,173,044,067.88 |
| D09 | 2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 421,793,425.59 | 1,563,823.30 | 4,570,118,801.16 | 4,993,476,050.05 |

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | | зөрүү | Хувь |
|-----------------------|--|-----------------------|----------------|---------------|-------|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл | | |
| 1 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 655,680,300.00 | 638,074,322.57 | 17,605,977.43 | 97.3 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 655,680,300.00 | 638,074,322.57 | 17,605,977.43 | 97.3 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 643,807,500.00 | 627,859,822.57 | 15,947,677.43 | 97.5 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 394,822,800.00 | 382,600,420.85 | 12,222,379.15 | 96.9 |
| 210101 | Үндсэн цалин | 317,642,300.00 | 316,764,801.80 | 877,498.20 | 99.7 |
| 210102 | Нэмэгдэл | 47,910,200.00 | 36,400,011.68 | 11,510,188.32 | 76.0 |
| 210104 | Урамшуулал | 29,270,300.00 | 29,435,607.37 | -165,307.37 | 100.6 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 50,101,100.00 | 48,847,310.22 | 1,253,789.78 | 97.5 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 37,347,700.00 | 36,295,597.13 | 1,052,102.87 | 97.2 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 3,188,400.00 | 3,218,306.50 | -29,906.50 | 100.9 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,550,600.00 | 2,575,100.73 | -24,500.73 | 101.0 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 637,700.00 | 614,686.65 | 23,013.35 | 96.4 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 6,376,700.00 | 6,143,619.21 | 233,080.79 | 96.3 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 136,239,200.00 | 135,784,066.50 | 455,133.50 | 99.7 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,357,500.00 | 4,025,576.00 | 331,924.00 | 92.4 |
| 210302 | Тулш, халаалт | 131,371,700.00 | 131,249,390.50 | 122,309.50 | 99.9 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 510,000.00 | 509,100.00 | 900.00 | 99.8 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 8,816,400.00 | 8,581,420.00 | 234,980.00 | 97.3 |
| 210401 | Бичиг хэрэг | 1,183,600.00 | 1,183,600.00 | 0.00 | 100.0 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,000,000.00 | 2,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 1,277,600.00 | 1,275,620.00 | 1,980.00 | 99.8 |
| 210404 | Ном, хэвлэл | 948,000.00 | 715,000.00 | 233,000.00 | 75.4 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,240,000.00 | 1,240,000.00 | 0.00 | 100.0 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,167,200.00 | 2,167,200.00 | 0.00 | 100.0 |
| 2105 | Нормативт зардал | 25,162,700.00 | 23,388,125.00 | 1,774,575.00 | 92.9 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 3,280,100.00 | 3,279,050.00 | 1,050.00 | 100.0 |
| 210502 | Хоол, хүнс | 16,833,800.00 | 15,060,275.00 | 1,773,525.00 | 89.5 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 5,048,800.00 | 5,048,800.00 | 0.00 | 100.0 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 20,789,400.00 | 20,789,100.00 | 300.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 17,650,000.00 | 17,650,000.00 | 0.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 3,139,400.00 | 3,139,100.00 | 300.00 | 100.0 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 307,500.00 | 301,000.00 | 6,500.00 | 97.9 |
| 210702 | Дотоод албан томилолт | 307,500.00 | 301,000.00 | 6,500.00 | 97.9 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 961,100.00 | 961,100.00 | 0.00 | 100.0 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 221,100.00 | 221,100.00 | 0.00 | 100.0 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 500,000.00 | 500,000.00 | 0.00 | 100.0 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 240,000.00 | 240,000.00 | 0.00 | 100.0 |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6607300.00 | 6607280.00 | 20.00 | 100.0 |

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| | | | | | |
|-------------|---|-----------------------|-----------------------|----------------------|--------------|
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 6,000,000.00 | 6,000,000.00 | 0.00 | 100.0 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 607,300.00 | 607,280.00 | 20.00 | 100.0 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 11872800.00 | 10214500.00 | 1,658,300.00 | 86.0 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 11,872,800.00 | 10,214,500.00 | 1,658,300.00 | 86.0 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 11,542,900.00 | 9,894,500.00 | 1,648,400.00 | 85.7 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 329,900.00 | 320,000.00 | 9,900.00 | 97.0 |
| | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 655,680,300.00 | 638,074,322.57 | 17,605,977.43 | 97.3 |
| 1310 | УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 518,441,100.00 | 501,290,256.07 | 17,150,843.93 | 96.7 |
| 131007 | Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих | 518,441,100.00 | 501,290,256.07 | 17,150,843.93 | 96.7 |
| 1320 | ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 137,239,200.00 | 136,784,066.50 | 455,133.50 | 99.7 |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 137,239,200.00 | 136,784,066.50 | 455,133.50 | 99.7 |
| 62 | АЖИЛЛАГСАДЫН ТОО | 33 | 33 | 0.00 | 100.0 |
| 620001 | Удирдах ажилтан | 1 | 1 | 0.00 | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 22 | 22 | 0.00 | 100.0 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 10 | 10 | 0.00 | 100.0 |
| 63 | СУРАЛЦАГЧДЫН ТОО (ЖИЛИЙН ДУНДЖААР) | 231 | 231 | 0.00 | 100.0 |
| 630 | ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН СУРГУУЛЬД СУРАЛЦАГЧИД | 231 | 231 | 0.00 | 100.0 |
| 630001 | Төрийн өмчит ЕБС | 231 | 231 | 0.00 | 100.0 |
| 65 | ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 33 | 33 | 0.00 | 100.0 |
| 650004 | СӨБ болон бага, дунд боловсролын албан хаагч (ТҮБД) | 23 | 23 | 0.00 | 100.0 |
| 650009 | Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 10 | 10 | 0.00 | 100.0 |

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

| Дансны код | Үзүүлэлт | төгрөгөөр | |
|-------------|--|---------------------|----------------------|
| | | Өмнөх он | Гүйцэтгэл |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| | НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 8,362,800.00 | 42,575,310.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 8,362,800.00 | 42,575,310.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 00.00 | 4,399,044.00 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | | 4,399,044.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | | 4,399,044.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 8362800.00 | 38,176,266.00 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 8,362,800.00 | 38,176,266.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | | 24,838,830.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 8362800.00 | 13,337,436.00 |
| II | ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 8362800.00 | 42,575,310.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 8,362,800.00 | 42,575,310.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 8362800.00 | 42,575,310.00 |
| IV | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)-(II)-(I) | | |

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Н.Бүнчинсүрэн гүйцэтгэж, чанарын хяналтыг ахлах аудитор М.Алтантуяа, аудитын менежер А.Цээням, Газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Мөнхбат нар тус тус хэрэгжүүлсэн.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийх хүсэлтийг Баянхонгор аймаг дахь Төрийн аудитын газарт 2022-ны 2 дүгээр сарын 23 өдрийн 08 дүгээр албан бичгээр ирүүлсэн.

2021 оны төсвийн хөрөнгийг захиран зарцуулах 1 дүгээр гарын үсгийг Жинст сумын сургуулийн захирал М.Бибиш, 2 дугаар гарын үсгийг нягтлан бодогч Б.Чулуундорж нар зурж байна.

3.2.1 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн үйл ажиллагааны чиглэлийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Багш ажлын байран дээрээ мэргэжлээ тасралтгүй дээшлүүлэх ажлыг хэвшүүлж багшийн хөгжлийн төвийг тоног төхөөрөмж, техник хэрэгслээр хангах.
- “Сайн багш” хөтөлбөрийг хэрэгжүүлэн, багш бүр ээлжит хичээлийн бэлтгэлийг чанартай хийж, ЗАН, секц, багаараа хамтран нээлттэй, судалгаат, хамтын, зочинтой хичээлүүдийг явуулдаг менежментийг сургууль, цэцэрлэг бүр хэрэгжүүлэх.
- Цэцэрлэг болон сургуулийн нийт сурагчдыг хамруулан хичээлээс гадуурх үйл ажиллагаагаар дамжуулан сурагчдын олон талт оюуны чадамжийг хөгжүүлэх зорилгоор математик сэтгэлгээг хөгжүүлэх нэмэлт сургалт, болон англи хэлний сургалтыг цэцэрлэг, сургуулийн наснаас нь сургах туршилтыг чанартай зохион байгуулна.
- Багшийн ажлыг мэдлэг, ур чадвар, сурган хүмүүжүүлэх үндсэн үйл ажиллагааны үр дүнгээр үнэлж урамшуулдаг болох.
- “Багшийн хөгжлийг дэмжих тухай хууль”-ийг хэрэгжүүлж, сургалтын байгууллага ёс зүйн зөрчлөөс ангид байхыг эрхэмлэн багш, ажилтан бүр ёс зүйн дүрмийг үйл ажиллагаандаа чанд мөрдөнө.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Баянхонгор аймгийн Санхүү хяналт, аудитын алба нь дотоод аудитын чиг үүргийг хэрэгжүүлдэг ба Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн үйл ажиллагаанд аудит хийгдээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшнийг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны үр дүнгийн тайлангийн нийт зардал 678,518.6 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 10,177.8 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 7,124.4 мянган төгрөгөөр тогтоосон.

Тогтоосон төлөвлөлтийн ерөнхий материаллаг байдлыг аудитын явцад гүйцэтгэлийн үе шатанд хянаж үзэхэд 2021 оны үр дүнгийн тайлангийн нийт зардлаас тооцоход 9,192.0 мянган төгрөг байгаа тул шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгө 4,993,476.1 мянган төгрөг байгаа бөгөөд өмнөх оноос 3,170,281.8 мянган төгрөгөөр буюу 173.9 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|--------------------|--------------------|--------------------|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 71,267.3 | 67,631.5 | (3,635.9) |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 12,568.7 | 2,453.3 | (10,115.4) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 58,698.7 | 65,178.1 | 6,479.5 |
| ЭРГЭЛТИЙН БҮС ХӨРӨНГИЙН ДҮН | 1,751,926.9 | 4,925,844.6 | 3,173,917.7 |
| Үндсэн хөрөнгө | 1,927,156.5 | 5,116,168.8 | 3,189,012.3 |
| Хуримтлагдсан элэгдэл | (175,229.6) | (190,324.2) | (15,094.6) |
| Нийт хөрөнгө | 1,823,194.2 | 4,993,476.1 | 3,170,281.8 |
| Өр төлбөр | 2,762.3 | - | (2,762.3) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,820,432.0 | 4,993,476.1 | 3,173,044.1 |
| Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн | 1,823,194.2 | 4,993,476.1 | 3,170,281.8 |

/Эх сурвалж: Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн 2021 оны санхүүгийн тайлангаас/

Авлагын дансны 12,568.7 мянган төгрөг болж 10,115.4 мянган төгрөгөөр буурсан нь 9,950.0 мянган төгрөгийн ухаалаг дэлгэцийг хүлээн авч авлага барагдуулсан, мөн 621.3 мянган төгрөгийн цалингийн урьдчилгааны авлага нэмэгдсэнтэй холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 65,178.1 мянган төгрөг болж 6,479.5 мянган төгрөгөөр өссөн нь тусгай зориулалтын материал 2,865.3 мянга, эм боох материал 4,60.1 мянга, аж ахуйн материал 389.0 мянга, хүнсний материал 3,275.0 мянган төгрөгөөр төсвийн хөрөнгөөр худалдан авч нөөцөлсөнтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 5,116,168.8 мянган төгрөг болж 3,173,917.7 мянган төгрөгөөр өссөн нь төсвийн хөрөнгөөр 20,337.1 мянган төгрөгийн хөрөнгө худалдан авсан, 3,350,635.9 мянган төгрөгийн үнэ төлбөргүй хөрөнгө шилжүүлэн авч Аймгийн ИТХ-ын Тэргүүлэгчдийн 2021.12.14-ны өдрийн 139 дүгээр тогтоолоор 182,737.8 мянган төгрөгийн барилга байгууламжийг Жинст сумын ЗДТГ-т балансаас баланст шилжүүлсэн, аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.05.18-ний өдрийн 43 дугаар тогтоолоор 9,172.8 мянган төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

Тайлант онд аймгийн ИТХ-ын тэргүүлэгчдийн 2021.06.21-ний өдрийн 81 дүгээр тогтоолоор улсын төсвийн хөрөнгө оруулалтаар барьж 2020 онд ашиглалтад орсон 2,378,055.3 мянган төгрөгийн өртөгтэй 240 хүүхдийн сургуулийн барилга, 963,408.4 мянган төгрөгийн өртөгтэй 150 хүүхдийн дотуур байр, БСУЯ-ны хөрөнгө оруулалтаар 8,951.3 мянган төгрөгийн тавилга, тоног төхөөрөмж нийт 3,350,585.9 мянган төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй орлого авсантай холбоотой байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 4,993,476.0 мянган төгрөг болж 3,173,044.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүн 3,173,044.1 мянган төгрөгийн өөрчлөлтөөс шалтгаалсан байна.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 650,432.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 650,432.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 59,569.4 мянган төгрөгөөр бууруулж 590,863.3 мянган төгрөгөөр анх батлагдсан ба төсвийн тодотголоор 64,361.9 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн цалин, НДШ, эд хогшил, урсгал засварын зардлыг нэмэгдүүлэн баталсан байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 7 арга хэмжээг санхүүжүүлэхээр 655,255.2 мянган төгрөгийн төсөв баталснаас 518,441.1 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс, 136,784.1 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс тусгай зориулалтын шилжүүлгээр 518,441.1 мянга, орон нутгийн төсвөөс 136,784.1 мянга, урсгал үйл ажиллагаанд 638,074.3 мянган төгрөгийг зарцуулж тусгай зориулалтын шилжүүлгээс 17,150.8 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 638,074.3 мянган төгрөг буюу 97.3 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшлаас 12,222.4 мянга, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл 1,253.8 мянга, байр ашиглалттай тогтмол зардал 455.1 мянга, хангамж бараа материалын зардал 235.0 мянга, хоол, хүнс 1,773.5 мянга, үдийн цайны зардлаас 1,648.4 мянган төгрөг тус тус хэмнэсэнтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 42,610.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж 42,610.3 мянган төгрөг зарцуулж 35.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн ба дээд шатны төсөв захирагчаас 24,838.8 мянган төгрөгийг 1 багшийн тэтгэвэрт гарахад нь олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж, 13,372.4 мянган төгрөгийг 3 багшид хөдөө орон нутагт тогтвортой ажилласан албан хаагчдад төрөөс дэмжлэг үзүүлэх тэтгэмж, Боловсрол, соёл урлагийн газраас тэтгэлэгт хөтөлбөрийн санхүүжилт 4,300.0 мянган төгрөг, БШУЯ-аас сурагчдын түвшин тогтоох шалгалтын бичиг хэргийн зардалд 99.0 мянга нийт 42,610.3 мянган төгрөгийн орлого орж гүйцэтгэлээр 42,575.3 мянган төгрөг зарцуулж 35.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Тус байгууллагын 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайланг аудитор Н.Бүнчинсүрэн аудит хийсэн бөгөөд тайлант оны санхүүгийн тайлангийн аудитаар өмнөх оны санхүүгийн тайлангийн мэдээллийг хамруулаагүй болно.

Байгууллагын жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөнд, 3 зорилтын хүрээнд 65 арга хэмжээ хэрэгжүүлэхээр төлөвлөж 92.3 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

3.8 Аудитын гол асуудал

Тус байгууллагын санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт зардал 875,427.3 мянган төгрөг байгаа нь өмнөх оноос 183,953.3 мянган төгрөгөөр буюу 26.6 хувиар өссөн байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан зардлууд нь, байр ашиглалттай холбоотой зардал, үндсэн хөрөнгийн элэгдэл хорогдлын зардал өмнөх оноос өссөн үзүүлэлттэй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Аудитаар тус хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийн давхардал, ач холбогдол, үр нөлөөг харгалзан Монгол Улсын Ерөнхий аудиторын 2021 оны А/108 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас шилэн дансны 2021-2022 оны үйл ажиллагаанд хөндлөнгийн хяналтыг хэрэгжүүлэх ерөнхий чиглэл”-ийн 1 дүгээр хавсралтад заасан 10 төрлийн мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулсан эсэхийг хамруулан шалгалаа.

Тус байгууллага нь 2021 онд нийт 941,775.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээний 184,395.8 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 85,869.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож

| д/д | Хугацаа | Төрөл | Мэдээлвэл зохих/удаа | Хугацаанд оруулсан | Хугацаа хоцроосон | Хугацаа болоогүй |
|-----|------------|-------|----------------------|--------------------|-------------------|------------------|
| 1 | Бүтэн жил | 11 | 11 | 8 | 1 | 2 |
| 2 | Хагас жил | 4 | 4 | 4 | 0 | |
| 3 | Улирал бүр | 1 | 4 | 3 | 1 | |
| 4 | Сар бүр | 3 | 36 | 34 | 2 | |
| 5 | Тухай бүр | 8 | 96 | 73 | 23 | |
| | Нийт | 27 | 151 | 122 | 27 | 2 |

байршуулсан нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

3.9.2 Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын хэрэгжилт

Тайлант онд нийт 655,225.2 мянган төгрөгийн төсөв батлагдаж гүйцэтгэлээр 638,074.3 мянган төгрөгийг зарцуулж оны эцэст 17,150.8 мянган төгрөг буюу төсвийн 2.6 хувийг буцаан төвлөрүүлсэн нь Засгийн газрын 2021 оны “Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай” 43 дугаар тогтоолтой нийцэхгүй байна.

Мөн үдийн цайны зардал нь оны эхэнд 18,675.9 мянган төгрөгөөр батлагдсан ба 7,133.0 мянга, дотуур хүүхдийн хоолны зардлыг оны эхэнд 58,963.8 мянган төгрөг батлагдаж 40,130.0 мянган төгрөгийг бууруулж аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч аймгийн Засаг даргын “Төсөвт зохицуулалт хийх тухай” А/289, А/742 дугаар захирамжуудаар цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан зэрэг зардлуудад тус тус гүйлгэн зарцуулсан байна.

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 140,318.6 мянган төгрөгөөр, тодотголоор 4,534.5 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 135,784.1 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

3.9.3 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, тайлант хугацаанд дотуур байрны хоол хүнс, үдийн цайны хүнсний материал нийлүүлэх худалдан авах ажиллагаа зохион байгуулан “Дотуур байрны хоол хүнс” нийлүүлэх гэрээг “Их богдын Ундарга” ХХК-тай, “Үдийн цайны хүнсний материал” нийлүүлэх гэрээг “Эх арцат” ХХК-тай тус тус байгуулсан байна

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар “Хязгаарлалттай” санал дүгнэлт авсан ба 189,394.0 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 13,3676.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 3,116.5 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 13,165.0 мянган төгрөгийн 2 албан шаардлага, 39,435.6 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн байна.

Хэрэгжилтийг Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн захирлын 2021.06.17-ны өдрийн 63 тоот албан бичгээр ирүүлж хэрэгжилтийг тооцсон байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Байхгүй.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар 320984.5 мянган төгрөгийн 4 зөрчил илэрч 3,456.5 мянган төгрөгийн 2 төлбөрийн акт тогтоож, 317,528.0 мянган төгрөгийн алдаа зөрчил давтан гаргахгүй 2 зөвлөмжийг хүргүүллээ.

4.1 Төлбөрийн акт

1. Жижүүр Л.Баянжаргалд 2021 оны 6 сард амралтын цалин, үр дүнгийн урамшуулал, цалинд 1,165.1 мянган төгрөг олгохоор тооцсон байхад гарт олгох цалин дээр нэмж 706.5 мянган төгрөгийг нэмж 1,871.7 мянган төгрөгийг олгосон байна. Мөн илүү олгосон 706.5 мянган төгрөгөөс 2021 оны 7 сард НДШ-д 81.2 мянга, ХАОАТ-ын 75.3 мянган төгрөгийг мэдээлж төсвөөс төлсөн

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-т “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ” 14.4.2-т “Бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага” гэсэн заалтууд Санхүүгийн тайлангийн “Үнэлгээ

ба хуваарилалт”, “Нийцсэн бөгөөд зохистой байх” байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн: Жижүүр Л.Баянжаргалаар төсвөөс илүү олгосон цалингийн 706.5 мянга, НДШ-ийн 81.2 мянга, ХАОАТ-ын 75.3 нийт 863.0 мянган төгрөгийг төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

2. “Эх арцат” ХХК-д 2021.03.24-ны өдөр 2,747.5 мянга, “Их богдын ундарга” ХХК -д 4,077.5 мянга нийт 6,825.0 мянган төгрөг шилжүүлж хүнсний материалыг худалдан авч 3 сарын үдийн цайнд 1,835.5 мянга, дотуур байрны хүүхдийн хоолны зардалд 3,139.3 мянган төгрөгийг зарцуулсан байна. Харин ковид-19 цар тахал гарсантай холбоотой сургууль хичээллээгүйтэй бөгөөд мах болон бусад хүнсний материал муудаж Жинст сумын сургуулийн захирлын 2021.10.01-ний өдрийн 46 дугаар тушаалаар 2,593.5 мянган төгрөгийн хүнсний материалыг акталсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 67 дугаар зүйлийн 67.1-т “Төрийн өмчит хуулийн этгээдийн эрх баригч нь өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтын байдалд өдөр тутам тавих дотоодын хяналтыг зохион байгуулж, түүний үр дүнг төрийн өмнө хариуцна.” гэсэн заалт, 67.2-т “Өмч хөрөнгийн хадгалалт, хамгаалалтад бүртгэлээр тавих хяналт шалгалтыг тухайн хуулийн этгээдийн ерөнхий нягтлан бодогч хариуцна” гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн: Устгасан 2,593.5 мянган төгрөгийн хүнсний материалыг буруутай албан тушаалтнаар төлүүлэхээр төлбөрийн акт тогтоов.

4.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Тус байгууллага нь 2021 онд нийт 941,775.0 мянган төгрөгийн 151 мэдээллийг Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас 27 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан ба Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 5 гүйлгээний 184,395.8 мянга, Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг (Тухай бүр) 85,869.2 мянган төгрөгийн гүйлгээг хугацаа хоцроож байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1 .дэх “Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ” 6.4 “ Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны хуулийн 6 дугаар зүйлийн 6.1, 6.4-т заасан мэдээлэл, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ зэрэг 3 мэдээллийг хоцроосон, мөн цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий зарлагын мэдээллийг хугацаанд нь үнэн зөв мэдээлж байх.

2. Үдийн цайны зардал нь оны эхэнд 18,675.9 мянган төгрөгөөр батлагдсан ба 7,133.0 мянга, дотуур хүүхдийн хоолны зардлыг оны эхэнд 58,963.8 мянган төгрөг батлагдаж 40,130.0 мянган төгрөгийг бууруулж аймгийн Санхүү Төрийн сангийн хэлтэст бүлэг хооронд гүйлгэн зарцуулах хүсэлт өгч аймгийн Засаг даргын “Төсөвт зохицуулалт хийх тухай “ А/289, А/742 дугаар захирамжуудаар цалин, НДШ, эд хогшил худалдан авах, гамшгийн эрсдэлийн сан зэрэг зардлуудад тус тус гүйлгэн зарцуулсан байна.

**Жинст сумын Ерөнхий боловсролын сургуулийн
2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан**

Байгууллагын ашиглалттай холбоотой тогтмол зардлын төсвийг анх 140,318.6 мянган төгрөгөөр, тодотголоор 4,534.5 мянган төгрөгөөр бууруулж оны эцэст 135,784.1 мянган төгрөгийг зарцуулсан нь ЗГ-ын 43 тогтоолын 1.8 дах заалттай нийцэхгүй байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах" Засгийн газрын 2021 оны "Төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээний тухай" 43 дугаар тогтоолын 1.1 "Үндсэн үйл ажиллагаатай холбоотой, зайлшгүй шаардлагатайгаас бусад бүх төрлийн зардал төсөл арга хэмжээг тэвчиж, зардлыг гаргахгүй зэргээр батлагдсан төсөвт зардлын дүнд 10-аас доошгүй хувийн хэмнэлт гаргахаар тооцож, урсгал болон хөрөнгө оруулалтын зардлыг төлөвлөн хуваарилах" гэсэн заалтуудыг тус тус зөрчсөн байна.

Өгсөн зөвлөмж

Цаашид Засгийн газраас төсвийн хэмнэлтийн талаар авах арга хэмжээ болон баримтлах чиглэлийн талаар гаргасан тогтоол болон журмыг хэрэгжүүлэн ажиллах

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

| д/д | Аудитад хамрагдсан байгууллагын нэр | Нийт алдаа, зөрчлийн | | Үүнээс | | | | | | | |
|-----|-------------------------------------|----------------------|-----------|-----------|-----|---------------|---------|-----------------|-----|---------|----------|
| | | | | Запруулга | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| 1 | Жинст сумын ЕБС | 4 | 320,984.5 | | | 2 | 3,456.5 | | | 2 | 317528.0 |

оОо